

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2019.01.09-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрээс:

1.1. “Онцгой байдлын байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө”-ний төслийн тухай хэлэлцээд Онцгой байдлын ерөнхий газрын даргаар батлуулж, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудад хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Онцгой байдлын байгууллагаас хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хэлэлцээд тайланг ЗГХЭГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.3. Онцгой байдлын байгууллагаас хэрэгжүүлж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд тайланг ЗГХЭГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.4. “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хэлэлцээд хэрэгжилтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар 90,2 хувьтай батлав.

1.5. “Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийн тухай хэлэлцээд холбогдох засвар өөрчлөлтийг тусган ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулахыг Ажлын хэсэгт даалгав.